

**Төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн
аж ахуйн нэгжүүдийн 2017 оны жилийн эцсийн
санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн танилцуулга**

Ерөнхий зүйл.

Төрийн аудитын байгууллагын Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу аймгийн төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийх баталгаажуулах аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”, гарын авлагын дагуу аудитыг хийж гүйцэтгэлээ.

Тус Аудитын газраас 2018 онд хийх санхүүгийн тайлангийн аудитын бэлтгэл ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 2.4.1-д заасан санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалтыг төрөл тус бүрээр боловсруулж, 2017 оны 6 дугаар сард ҮАГ-ын Санхүүгийн аудитын газарт хүргүүлсэн.

Байгууллагын хүний нөөцийн боломжийг тооцсоны үндсэн дээр нийт 241 байгууллага, төсөл сангуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхээс 133 санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргаж, 71 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 37 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлэн өнжөөхөөр хуваарийн төсөлд тусгасан.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн “Аудит хийх жагсаалтыг баталгаажуулах тухай” А/134 тоот тушаалаар төсвийн байгууллага, төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийх аудитын жагсаалтыг баталж, 2018 оны 1 дүгээр сарын 05-ны өдрийн А/05 дугаар тушаалаар жагсаалтыг шинэчлэн баталсан.

Дээрх тушаалуудыг хэрэгжүүлэх зорилгоор аудитын хуваарийг боловсруулж Тэргүүлэх аудиторын тушаалаар батлуулан, хэрэгжилтийг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллалаа.

Аудитын газраас хийх Завсарын аудитын төлөвлөгөөг 2017 оны 10 дугаар сард батлуулж, 11-12 дугаар сард 80 гаруй байгууллагад завсарын аудит хийлээ.

Энэ жилийн санхүүгийн тайлангийн аудитын ажилд Аудитын газрын 8 аудитор, гэрээт болон хувийн аудитын компаний 2 аудитор ажиллаж, нийтдээ 658 хүн өдөр зарцуулж, ажлын шаардлагаар ажлын болон амралт, нийтээр амрах баяр ёслолын өдрүүдэд 1136 цаг илүү цагаар ажиллав.

Хоёр.Санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар.

Тус аудитын газар нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх заалтад хамрагдах **181** байгууллагын 241 санхүүгийн тайланд аудит хийхээс төсвийн шууд захирагч 108, тусгай сан 3, аж ахуйн нэгж 6, төсвийн төвлөрүүлэн захирагч 15, төсвийн ерөнхийлөн захирагч 1, бүгд 133 нэгжийн санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргаж, төсвийн шууд захирагч 30, орон нутгийн 41 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 37 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд итгэл үзүүлж өнжөөсөн болно.

Санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитаар 119 санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт, 13 санхүүгийн тайланд хязгаарлалттай санал дүгнэлт, 1 санхүүгийн тайланд сөрөг санал дүгнэлт өгөв.

Бие даасан дүгнэлт гаргасан 133 байгууллагыг 100%, түүвэрт хамруулсан 71 санхүүгийн тайлангийн 58-ийг буюу 81,7 хувийг өөрсдийн аудиторуд хийж гүйцэтгэлээ. Харин түүвэрт хамруулсан 13 санхүүгийн тайланг гэрээт болон хувийн аудитын компаны аудиторуд баталгаажууллаа.

Аудитын дүнгээр нийтдээ **2330,3** сая төгрөгийн алдаа зөрчил илэрч үүнээс 565,9 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад санхүүгийн тайланд тусгуулан залруулж, 59,0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1419,7 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгч, 285,7 сая төгрөгийн алдаа зөрчилд 26 заалт бүхий зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүллээ.

Аудитаар илэрсэн нийт алдаа зөрчлийн 42,6 хувийг нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой, 41,9 хувийг хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, 6,4 хувийг дотоод хяналт, хариуцлагатай холбоотой, 9,1 хувийг бусад алдаа зөрчлүүд эзэлж байна.

Илэрсэн нийт алдаа зөрчлийн 1753,0 сая төгрөг буюу 75,2 хувь нь төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангаас, 64,3 сая төгрөг буюу 2,8 хувь нь аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангаас, 513,0 сая төгрөг буюу 22,0 хувь нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаас тус тус илэрсэн байна.

Аудитын дүнгээр хязгаарлалттай, сөрөг санал дүгнэлт авсан байгууллагуудын 16 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлагыг холбогдох байгууллагын албан тушаалтнуудад хүргүүлэв.

2.1.Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасан хугацаанд санхүүгийн тайлангаа ирүүлэх ёстой нийт 219 төсвийн шууд захирагч, сангуудын санхүүгийн тайланг баталгаажуулах ёстойгоос 111 байгууллагын санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргаж, орон нутгийн

30 төсвийн шууд захирагч, 41 төсөл сангуудын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 37 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлж өнжөөв.

Аудитын дүнгээр 111 санал дүгнэлт гаргаснаас 100 байгууллагын санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт, 11 байгууллагын санхүүгийн тайланд хязгаарлалттай санал дүгнэлт өгөв.

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар нийтдээ **1753,0** сая төгрөгийн алдаа зөрчил илэрч үүнээс 199,0 сая төгрөгийн алдааг залруулж, 48,3 сая төгрөгийн зөрчилд акт тогтоож, 1220,0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 185,7 сая төгрөгийн зөрчлийг засаж залруулахаар 23 заалт бүхий зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангаас илэрсэн алдаа, зөрчлийг хураангуйлан харуулбал:

- Орон нутгийн харьяа төсөвт байгууллагуудын 2017 оны батлагдсан төсөвт орон тооны хязгаарыг нийт 4795.5 хүнээр баталсан ба гүйцэтгэлээр 5023.5 хүн ажиллуулж орон тооны хязгаарыг 288 хүнээр хэтрүүлжээ. Үүнд: Орон нутгийн төсвийн байгууллагууд 40.5 хүнээр, Боловсрол соёл урлагийн салбарын байгууллагууд 140 хүнээр, Эрүүл мэндийн салбарын байгууллагууд 42.5 хүнээр, бусад байгууллагууд 5 хүнээр орон тоог хэтрүүлэн ажиллуулжээ.
- Орон нутгийн төсөвт байгууллагууд оны эцэст нийтдээ 1501.0 сая төгрөгийн өглөгтэй гарч өглөг оны эхнээс 668.4 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд: Орон нутгийн төсвийн байгууллагууд 1053.1 сая төгрөгийн, Боловсрол соёл урлагийн салбарын байгууллагууд 388.2 сая төгрөгийн, Эрүүл мэндийн салбарын байгууллагууд 59.7 сая төгрөгийн өглөгтэй гарчээ.
- Аймгийн Нийгмийн халамжийн сангийн дансны үлдэгдэл, санхүүжилтээс 2016 оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын дансанд татан төвлөрүүлсэн 737,3 сая төгрөгийн хөрөнгийг буцаан олгоогүй, Нийгмийн халамжийн сангийн 2017 оны төсвийг үндэслэлгүй бууруулж баталсны улмаас оны эцэст нийт 948,3 сая төгрөгийн өглөгтэй гарч өглөг оны эхнээс 350,4 сая төгрөгөөр нэмэгдэж, он дамжсан өртэй гарахад хүргэсэн байна.
- Цалингийн урьдчилгааны суутган тооцоог хийгээгүй, тайланд тусгаж харуулаагүй 6,1 сая төгрөгийн зөрчлийг 3 байгууллага гаргажээ.
- Төсвийн хөрөнгөнөөс 92,2 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг 13 байгууллага гаргажээ.
- Сахилгын шийтгэлтэй ажилтнуудад сахилга хариуцлага, ажлын үр дүнгийн урамшуулал олгосон 20,6 сая төгрөгийн зөрчлийг 18 байгууллага гаргажээ.

- ХХОАТ, НДШ-ийн тооцоогоор үүссэн өр, авлагыг санхүүгийн тайланд тусгаж харуулаагүй, тайланд зөрүүтэй тусгасан 15,3 сая төгрөгийн зөрчлийг 12 байгууллага гаргажээ.
- Бараа материалын тайланг зохих журмаар гаргаагүй, түүнд нягтлан бодогч нь хяналт тавьж ажиллагаагүй 53,2 сая төгрөгийн зөрчлийг 2 байгууллага гаргажээ.
- Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч, Төрийн сангийн зохих зөвшөөрөлгүйгээр төсвийн зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан 101,0 сая төгрөгийн зөрчлийг 12 байгууллага гаргажээ.
- Жилийн эцэст тооллого хийсэн боловч тооцоог бодож, хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй 112,9 сая төгрөгийн зөрчлийг 2 байгууллага гаргажээ.
- Үнэ төлбөргүй олгосон бараа материал, хөрөнгийг орлого аваагүй 98,0 сая төгрөгийн зөрчлийг 5 байгууллага, ОНХСангийн хөрөнгөөр хийгдсэн барилга байгууламжийг дуусаагүй барилга данснаас шилжүүлж бүртгээгүй зөрчлийг 1 байгууллага гаргажээ.
- Анхан шатны бүрдэл дутуу баримтаар хөрөнгө зарцуулсан 161,9 сая төгрөгийн зөрчлийг 4 байгууллага гаргажээ.

2.2.Төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасан хугацаанд санхүүгийн тайлангаа ирүүлэх ёстой төрийн болон орон нутгийн өмчийн 6 аж ахуйн нэгжийг аудитад бүрэн хамруулж, санхүүгийн тайланг баталгаажууллаа.

Аудитын дүнгээр 5 аж ахуйн нэгжид зөрчилгүй, 1 аж ахуйн нэгжид хязгаарлалттай санал дүгнэлт гаргав.

- “Хала өркени” ОНӨААТҮГазар жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй, тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.
- “Суат” ХХК нь 60,4 сая төгрөгийн худалдан авсан бараа материалыг орлого авалгүйгээр нягтлан бодох бүртгэлд шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

2.3.Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Төсвийн тухай хуулийн 8.9.3-т заасан хугацаанд санхүүгийн тайлангаа ирүүлэх 14 сумын болон Нийгмийн даатгалын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргав.

Аудитын дүнгээр 13 төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт өгч, Ногооннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд хязгаарлалттай, Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн

санхүүгийн тайлангаас илэрсэн алдаа зөрчлийн материаллаг шинж байдлыг харгалзан сөрөг санал дүгнэлт өгөв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар нийтдээ **513,0** сая төгрөгийн алдаа зөрчил илэрч үүнээс 366,9 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 9,9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 136,2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн талаар:

- Ногооннуур сумын засаг дарга орон нутгийн төсөвт орох 4.8 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсвийн ерөнхий орлогын дансаар дамжуулахгүйгээр ЗДТГазрын нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулж, төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлд оруулж тайлагнаагүй, нэмэлт санхүүжилтээр тайлагнаж, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчиж албан тушаалын эрх хэмжээг хэтрүүлжээ.
- Бугат сумын Засаг дарга агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогоос 49.1 сая төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын дансанд оруулахгүйгээр арилжааны банкинд зөвшөөрөлгүй данс нээж сумын ИТХурлын шийдвэр, Төсвийн ерөнхийлөн захирагчийн зөвшөөрөлгүйгээр нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан урсгал зардалд зарцуулан сумын төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлд оруулж тайлагнаагүй, нэмэлт санхүүжилтээр тайлагнаж Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчиж албан тушаалын эрх хэмжээгээ хэтрүүлжээ.
- Баяннуур сумын Засаг дарга Сум хөгжүүлэх сангаас "Уламжлалт ав" ХХК-д 5,0 сая төгрөгийг шилжүүлж, тооцоо хийж санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй, шууд зардлаар бүртгэж, сангийн хөрөнгийг зориулалт бус зарцуулжээ.
- Сумууд нь ОНХСан, Сум хөгжүүлэх сангийн нягтлан бодох бүртгэл, тооцоог санхүүгийн бус мэргэжилтнүүдэд хавсруулан гүйцэтгүүлж Засгийн газрын 2014 оны "Санхүүгийн алба байгуулах тухай" 326 дугаар тогтоолын хавсралтаар баталсан нягтлан бодогч нарын ажлын чиг үүргийг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайланг зохих журмаар гаргаагүй зөрчил бүх сумуудаас нийтлэг гарсан байна. Энэхүү зөрчлийг арилгах талаар сумын Засаг дарга нарт албан бичгээр үүрэг өгөгдлөө.

Аудитын дүнгээр аймгийн Засаг даргад Бугат, Ногооннуур сумын Засаг дарга нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгч, Бугат сумын төсвийн хууль тогтоомж зөрчиж зориулалт бус зарцуулсан 49.1 сая төгрөгийн асуудлыг хуулийн байгууллагад шалгуулахаар шилжүүллээ.

2.4.Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, аймгийн 2017 оны Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хуулийн хугацаанд аудит хийж, зөрчилгүй санал дүгнэлт гаргалаа.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 8.9.4-д заасан хугацаанд ирүүлсэн боловч Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс харьяа байгууллагуудын санхүүгийн тайланг Засгийн газрын Э-тайлан цахим программд хянан баталгаажуулах ажил хангалтгүй хийгдэж, өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Ирүүлсэн санхүүгийн тайлангийн зарим тоо мэдээлэл аудит хийсэн санхүүгийн тайлангуудын нэгтгэлээс зөрүүтэй байснаас бүх байгууллага, сангуудын санхүүгийн тайланг Э-тайлантай нэг бүрчлэн тулгаж, зөрүүг арилгасан нь аудитын ажилд ихээхэн хүндрэл чирэгдэл учрууллаа.

Санхүүгийн тайлангийн тэмдэглэл, тайлбар, тодруулгыг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэмдэглэл, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэж ирүүлээгүй болно.

Аудитын дүнгээр аймгийн Засаг даргад дараах зөвлөмжийг хүргүүлэв.

- Санхүү, төрийн сангийн хэлтсээс Орон нутгийн бүх байгууллага, аж ахуйн нэгж, төсөл сангуудын аудит хийгдсэн санхүүгийн тайланг Э-тайлан программд нэг бүрчлэн тулгалт хийж зөрүүг арилган, хянан баталгаажуулж ажиллах, энэхүү зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх.
- Аймгийн Орон нутгийн харьяа төсөвт байгууллагууд орон тооны хязгаарыг хэтрүүлсэн зөрчлийг арилгаж Төсвийн тухай хуулийн 6.4.1, 6.4.8, 16.5.2, 16.5.3, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалтуудын хэрэгжүүлж, батлагдсан орон тооны хязгаарыг мөрдөж ажиллах.
- Аймгийн Орон нутгийн харьяа төсөвт байгууллагууд оны эцэст 1501.0 сая төгрөгийн өглөгтэй гарч өглөг оны эхнээс 668.4 сая төгрөгөөр өссөн зөрчлийг Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 39 дүгээр зүйлийн 39.4.2, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг мөрдөж өр төлбөр нэмж үүсгэхгүй байх, он дамжсан өр төлбөрийг бүрэн барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

Аймгийн 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлээс үзэхэд төсвийн орлогын төлөвлөгөөг 72574,8 сая төгрөгөөр баталж, 6813,0 сая төгрөгийг орон нутгийн төсвийн орлогоос, 64379,1 сая төгрөгийг тусламж, санхүүжилтийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр нийтдээ 71192,1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөснөөс 1382,7 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарчээ.

Орон нутгийн татварын орлогоос 7,614.3 сая төгрөгийг оруулж, төлөвлөгөөг 123,7 хувиар буюу 1,457.8 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Сумын татварын орлогын төлөвлөгөө 988,7 сая төгрөгөөр буюу 118,4 хувиар, аймгийн татварын орлогын төлөвлөгөө 467,9 сая төгрөгөөр буюу 7,8 хувиар давж биелэгджээ.

Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэлээр 71282,9 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвөөс 1,8 хувиар буюу 1291,9 сая төгрөгөөр бага зарлага гаргажээ. Энэ нь Сум хөгжүүлэх сангийн төлөвлөгөөг үндэслэлгүй илүү төлөвлөж, зээлийн эргэн төлөлт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байгаатай холбоотой байна.

Төсвийн зарлагын эх үүсвэрийн 49009,6 сая төгрөгийг улсын төсвөөс, 20569,5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1613,0 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос тус тус санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зарлагын 31,1 хувийг орон нутгийн төсвийн байгууллагуудын 68,8 хувийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага эзэлж байна.

Төсвийн зарлагын 73,1 хувийг бараа үйлчилгээний зардал, 24,1 хувийг урсгал шилжүүлэг, 0,1 хувийг татаас шилжүүлэг, 2,7 хувийг дотоодын хөрөнгө оруулалт эзэлж байна.

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР